



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 5/39

Хэрлэн сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын аймгийн Засаг даргатай байгуулсан 2016 оны жилийн эцсийн ажлыг үнэлсэн Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт ур чадварын нэмэгдлийг хавсралтад дурьдсаны дагуу 2017 оны 2 сараас эхлэн жилийн хугацаанд олгосугай.

Хоёр. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын ур чадварын нэмэгдлийн хэмжээг дээрх хувиар жилийн төсөвт багтаан тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд, жинхэнэ ажилласан цагт ногдох албан тушаалын цалингаас тооцож олгохыг сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны  
дугаар сарын 17-өдрийн 6/39  
дугаар захирамжийн хавсралт

Ур чадварын нэмэгдэл олгох сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нар

д/д	Байгууллагын нэр	Эрхлэгч, захирлын нэр	Нэмэгдэл олгох хувь
1	Тэмүүжин цогцолбор сургуулийн захирал	М.Золзаяа	30 %
2	Мөрөн сумын сургуулийн захирал	М.Ариунаа	20%
3	Батширээт сумын сургууль	Ц.Цогзолмаа	20%
4	НТБТ-ийн захирал	Г.Дашдаваа	20%
5	Бор-Өндөр сумын Энхжин цэцэрлэгийн эрхлэгч	О.Нарантуяа	30%
6	Бор-Өндөр сумын Нархан цэцэрлэгийн эрхлэгч	Г.Энхсаруул	20%
7	Бор-Өндөр сумын Бүжинхэн цэцэрлэгийн эрхлэгч	Р.Мөнгөнтуул	20%
8	Галшар сумын цэцэрлэгийн эрхлэгч	Д.Оюунгэрэл	20%
9	Хурх тосгоны цэцэрлэгийн эрхлэгч	Л.Энхтуяа	20%
10	Цэнхэрмандал цэцэрлэгийн эрхлэгч	П.Гантуяа	20%
11	Бор-Өндөр сумын Нархан цэцэрлэгийн эрхлэгч	Г.Энхсаруул	20%
12	Хэрлэн 1 цэцэрлэгийн эрхлэгч	Д.Болортулга	20%
13	Хэрлэн 4 цэцэрлэгийн эрхлэгч	Б.Энхтуяа	30%